



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 0128

Улаанбаатар хот

Инженерийн баг, хяналтын
инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалт, ИНД-171.79(а).6.3 “Туршилт шалгалтаар байгууламжийг түр ажиллуулах журам”-ын 6.3.1.1, 6.3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алсын удирдлагатай хэт богино долгионы RCAG станцын дуун холболтын удирдлагын төхөөрөмж /S4 controller/-ийг Богд-Уулын хэт өндөр давтамжийн радио нэвтрүүлэх төв байранд байрлах RCAG 121.5 MHz станцтай түр холбож шалгалт, тохируулгын ажлыг тестийн 123.450 MHz давтамж дээр хийж гүйцэтгэх инженерийн баг, хяналтын инженерийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Инженерийн багийн ахлагч:	Б.Төмөрбаатар	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн ахлах инженер
Гишүүд:	Э.Булган	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн ахлах инженер
	Б.Ернар	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер
Хяналтын инженер:	Д.Оюунболд	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн ахлагч инженер

2. Тоног төхөөрөмжийг түр холбох, шалгалт, тохируулгын ажлыг 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн дотор гүйцэтгэх, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүй, нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангахаар зохион ажиллахыг инженерийн багийн ахлагч Б.Төмөрбаатар, хяналт тавьж ажиллахыг хяналтын инженер Д.Оюунболд нарт тус тус үүрэг болгосугай.

3. Инженерийн баг, хяналтын инженерт байнгын хяналт тавьж ажиллахыг
Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба /Д.Баяртогтох/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН